



## Унгар улсын Будапешт хотын

ЭЛТЭ Өтвөш Лорандын нэрэмжит Их Сургууль болон

Кароли Гашпарын нэрэмжит Реформат Их Сургуульд

2025 оны 4 дүгээр сарын 8–9 өдөрт болох

## “МОНГОЛЫН БУРХНЫ ШАШНЫ БИЧГИЙН БА АМАН УЛАМЖЛАЛ”

сэдэвт монголын бурхны шашны олон улсын эрдэм

шинжилгээний 5 дугаар хуралд оролцохыг урьж байна.

2025 онд Унгарын монгол судлалыг дэлгэрүүлэгч нэрт монголч эрдэмтэн профессор Кара Дьөрдь (Хар Дорж)-ийн мэндэлсний 90 жилийн ой, Унгар-Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тэмдэглэх болно. Эдгээр олон үйл явдлыг тэмдэглэхээр Унгар улсын зүгээс олон төрлийн үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулан ажиллаж байна.

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд монголын бурхны шашны сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний тавдугаар хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 8–9-ний өдрүүдэд зохион байгуулахад хувь нэмрээ оруулахыг хүсье. Уг эрдэм шинжилгээний хурлыг ЭЛТЭ Өтвөш Лорандын нэрэмжит Их Сургуулийн Монгол ба Төв Ази Судлалын Тэнхим, Монгол Судлалын Төв, Унгар ба Монгол улсын төрийн болон төрийн бус олон байгууллагууд хамтран зохион байгуулна.

Унгар улс: – Кароли Гашпарын нэрэмжит Реформат Их Сургуулийн Дорнод Ази Судлалын Хүрээлэн  
– ЭЛТЭ Өтвөш Лорандын нэрэмжит Их сургуулийн Буддын Шашин Судлалын Төв  
– “Номын үүд” Буддын сүм  
– Унгарын Судалгааны Сүлжээний Угсаатан Судлалын Хүрээлэн  
– Унгарын Шинжлэх Ухааны Академийн Номын Сан, Мэдээллийн Төвийн Дорно Дахины Сан Хөмрөг

Монгол улс: – Монгол Улсаас Унгар Улсад суугаа Элчин Сайдын Яам  
– МБШТ Гандантэгчэнлин хийд  
– Монгол Улсын Их Сургуулийн Монгол Судлалын Хүрээлэн  
– Олон Улсын Монгол Судлалын Холбоо  
– Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Монгол Судлалын Хүрээлэн  
– Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолийн Хүрээлэн  
– Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Монголын Бурханы Шашны Их Сургууль  
– Будда Дарма шашин, өв соёл судлалын хүрээлэн ТББ

Монголын бурхны шашны олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2015 онд “Өнгөрсөн, одоо, ирээдүй”, 2017 онд “Бурхны шашны зан үйл”, 2019 онд “Уламжлал ба шинэчлэл”, 2022 онд “Амьтан, ургамал, байгаль хамгаалал” гэсэн сэдвүүдээр дөрвөн удаа амжилттай зохион байгуулжээ. Энэ удаагийн 5 дугаар хурлыг 2025 оны 4 дүгээр сард “Монголын бурхны шашин: бичгийн ба аман уламжлал” сэдвийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөж байна.

Монголын бурхны шашны уламжлал олон зууны тэртээгээс улбаатай бөгөөд шашны сургаал номлол нь бичгийн ба аман хэлбэрээр хадгалагдан үлджээ. Шашны олон зүйл судар ном, шашны түүх, гүн ухаан зэрэг бүтээлээс гадна домог зүй, үлгэр, хууч яриа нь судалгааны үнэтэй эх сурвалж болдог. Энэхүү хурал нь монголын бурхны шашин, хүрээ хийдүүдийн түүх, эрдэмт лам нарын намтар, гүн ухаан, боловсрол, зан үйл, эх бичиг, аман түүх, ардын аман зохиол тухай эрдэмтэн судлаачид, лам хуврагууд хурлын сэдвийн хүрээнд өөрсдийн судалгааны сэдвийг



танилцуулж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж, санал бодлоо солилцох таатай боломж бүрдүүлэхийг хурал зохион байгуулагчдын зүгээс зорьж байгаа болно.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлаар өнөөгийн Монголын нутаг дэвсгэрт амьдарч буй монголчуудын бурхан шашин, Орос ба Хятад улс, бусад газарт амьдарч буй монгол угсаатнуудын итгэл үнэмшил, ёс заншлын талаар хэлэлцэх бөгөөд Монголын уламжлалт бурхны шашны өвөрмөц онцлогийг хуралд танилцуулагдах илтгэлүүдээс харж болно.

Тус хуралд хэлэлцэгдэх илтгэлүүдийг эмхтгэл болгон хэвлэнэ.

Унгар улсын алдартай дорно дахин судлаач, хэл шинжлэлч, монголч эрдэмтэн, Унгарын ШУА-ийн гадаад гишүүн, ЭЛТЭ Өтвөш Лорандын нэрэмжит Их Сургуулийн Монгол ба Төв Ази Судлалын Тэнхим, ШУА-ийн Алтай Судлалын Төвийн эрхлэгч, профессор Кара Дьөрдь (Хар Дорж, 1935–2022) нь “Монголын нүүдэлчдийн ном”-ын судалгааны тэргүүлэгч, монголчуудын түүхэндээ хэрэглэж ирсэн олон төрлийн бичиг үсэг, алдар нэртэй лам нарын зохиол бүтээл, монгол хэл бичгийн судалгаанд онцгой хувь нэмэр оруулсан эрдэмтэн юм. Профессор Кара Дьөрдийн судалгааны ажил, хэл бичгийн ухааны талаар тавих илтгэлийг бид баяртай хүлээн авах болно.

Олон улсын эрдэм шинжилгээний хурал англи, монгол, орос хэлээр явагдана.

Хурлын үеэр зохион байгуулагчид хөнгөн зуушаар үйлчлэх болно. Оролцогчид энд байрлах хугацааны аялал, орон сууцны төлбөрийг өөрөө хариуцах шаардлагатай. Хэрвээ оролцогч та бүхэнд байрлах байрны талаар тусалцаа хэрэгтэй бол зохион байгуулагчдад хандаж болно.

Хуралд оролцогч та бүхэн хурлын өмнөх өдөр буюу 4 дүгээр сарын 7-ны өдөр үдээс хойш Унгарын Шинжлэх Ухааны Академийн Номын Сан, Мэдээллийн Төвийн Дорно Дахины Сан Хөмрөгийг үзэх боломжтой. Хурлын анхны өдөр буюу 4 дүгээр сарын 8-нд ЭЛТЭ Өтвөш Лорандын Их Сургууль дээр, дараагийн өдөр буюу 4 сарын 9-нд Кароли Гашпарын нэрэмжит Реформат Их Сургууль дээр болно.

Хуралд оролцох хүсэлтэй эрдэмтэн судлаачид **2025 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн** дотор овог нэр, байгууллагын нэр, илтгэлийн нэр болон 150 үгэнд багтаасан илтгэлийн хураангуйг [mongol@btk.elte.hu](mailto:mongol@btk.elte.hu) цахим хаягаар илгээнэ үү! Хэрвээ виза авахад шаардлагатай урилга хэрэгтэй бол бидэнд мэдэгдэнэ үү!

Тус эрдэм шинжилгээний хурлын талаарх мэдээллийг доорх хаягаас авч болно:

<https://www.innerasia.hu/event/mongolian-buddhism-conference-2025>

2025 оны 4 дүгээр сарын 4–5-нд Бүгд Найрамдах Чех Улсын Брно хотын Масарикийн Их Сургуулиас “Төв Ази дахь орон нутгийн түүх, хүрээлэн буй орчин хийгээд нүүдлийн мал аж ахуй (шилжилт хөдөлгөөнтэй мал аж ахуй)” олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдах болохыг анхаарна уу.

Будапешт хотод уулзахын ерөөл дэвшүүлье.

Зохион байгуулах хорооны нэрийн өмнөөс:

Др. Бирталан Агнэш  
Монгол ба Төв Ази Судлалын тэнхим,  
Монгол Судлалын Төвийн эрхлэгч,

Будапешт хот, 2024 оны 11 дүгээр сарын 10